



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн тудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn, http://www.city.audit.mn

2017.3.9. № 515

танай _____ -ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗАРТ

Санхүүгийн тайлангийн аудитын гэрчилгээ,
аудитыг дуусгавар болгосон тухай тайланг хүргүүлж
байна.

Хавсралт хуудас

ДЭД ДАРГА

С.ЭНХБААТАР





ҮНДЭСНИЙ АУДИТИН ГАЗАР
НИЙСЛЭЛИЙН АУДИТИН ГАЗАР

14191 Улаанбаатар хот, Сүрьеэдийн дүүрэг,
8 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны 5 дугаар байр,
Утас: 32-77-34, Факс: (976-11) 32-01-54,
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2014. 3. 09. № 514
таний _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА
Д.БАТСҮХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Нийслэлийн аудитын газраас аудит хийв.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Нийслэлийн аудитын газар нь Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2016 оны санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Нийслэлийн аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглувансан.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ОЧИРБАТ



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

Аудитын тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэг
дараах хаягаар харилцана уу:

С.Энхбаатар
Нийслэлийн аудитын газрын дэд
дарга
өрөөний утас: 327744

Д.Энхдалай
Санхүүгийн аудитын
I албаны менежер
өрөөний утас: 315558

И.Эрдэнэцэцэг
Ахлах аудитор
өрөөний утас: 325093

ТАБ-ын хаяг:
Улаанбаатар хот Сүхбаатар
дүүрэг, Ж.Лхагвасүрэнгийн
гудамж, Нийслэлийн засаг
захиргааны V байр

E mail: ub@audit.mn

Вэб: www.city.audit.mn

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Байгууллагаас ирүүлсэн хариу

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн
тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.2-д заасан Нийслэлийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд Нийслэлийн аудитын газар НАГ-2017/156/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн, Төрийн аудитын, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2016 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн Сангийн яамнаас гаргасан заавар, журам, тухайн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго юм.

Төсвийн захирагч нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэлийн аудитын газрын үүрэг юм.

Тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 09-наас 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Нийслэлийн аудитын газрын СА-ын I албаны II багийн ахлах аудитор И.Эрдэнэцэцэг 2017 оны 2 дугаар сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Тус газар нь 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 09-нд Нийслэлийн аудитын газарт ирүүлсэн нь хуульд заасан хугацааг 11 хоногоор хэтрүүлжээ.

Аудитын тайлан, гэрчилгээг 2017 оны 3 дугаар сарын 9-нд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын удирдлагад гардуулав.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын төсвийн захирагч нь Төсвийн, Нягтлан НАГ-2017/156/СТА-ТШЗ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь "Аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах нэгдсэн бодлогыг Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж, аялал жуулчлалын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хотын аялал жуулчлалын нөөцийг эргэлтэнд оруулах, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, цргэдтэй хамтарч ажиллах, олон улсын байгууллагын дэмжлэгээр аялал жуулчлал хөгжүүлэх бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх замаар хотын байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжилд тухайн салбарын эзлэх байр суурийг нэмэгдүүлэх" гэж зорилго тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16.1 "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасны дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга нь Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2016 оны үйл ажиллагааг Нийслэлийн төрийн сангаас санхүүжүүлж, санхүүжилтийг нийслэлийн төрийн сангаар дамжуулан олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хууль, журам, зааврын хэрэгжилт зарим талаар хангалтгүй байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2016 оны санхүүгийн тайланда дүгнэлт өгөх үүднээс байгууллагын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материалыг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансадад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 10-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын няглан бodoх бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөн ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн. Уг бодлогын баримт бичигтэй бүртгэлийн програм уялдсан байна. 2015 оны төсвийн ангилал шинэчлэгдсэнд дагуу НББББ-ийг шинэчлэн боловсруулаагүй, харин програмд өөрчлөлт оруулсан байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ гарс ан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн тооцоолох компаний "Acolous" програмаар боловсруулан санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дотоод хяналт эрдээлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Нийслэлийн Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын төсвийн захирагч нь 2016 онд нийлэлийн төсвөөс урсгал зардалд 258,289.3 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 224,442.7 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч үйл ажиллагааны зардалд 215,995.5 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 8,447.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтээр Нийслэлийн Засаг Даргын Тамгын газраас Найрсаг улаанбаатар хөтөлбөрийн санхүүжилт 433,912.8 мянга, урьд оны төсвийн хэмнэлтээс 4,480.0 мянга, Үндэсний их баяр наадмын санхүүжилт 19,000.0 мянга

НАГ-2017/156/СТА-ТШ3

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

НИЙТ 457,392.8 мянган төгрөгийн орлого орсноос 435,611.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 21,781.8 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн, үүнээс 15,779.0 мянган төгрөгийг төсвөөс авах авлага, харилцагчид өгөх өглөгөөр бүртгэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл:

Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2016 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дун бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг мэдээллийг байршуулсан эсэхэд 2016 оны 4, 10 дугаар саруудад нийцлийн аудит хийгдсэн болно.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 10 горим, сорилт гүйцэтгэв.

Анхан шатны нотлоо баримтгүй гүйлгээ бүртгэж зардал гаргасан, төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, бараа материалыг ангилалын дагуу бүртгээгүй, эзлжийн амралтын олговрыг илүү тооцож олгосон, хууль, журмыг хэрэгжүүлж зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх, хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулах, төсвийн зориулалтыг зөрчих, үргүй зардал гарах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг нотлохын тулд түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, орлого, цалин зарим зардлууд, бараа материал, үндсэн хөрөнгө зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 75 хувь, нийт зардлын 75.7 хувь, нийт хөрөнгийн 17.6 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад **материаллаг бус** хэмжээний 80,208.3 мянган төгрөгийн алдаа илэрлээ. Үүнд:

1. Татан төвлөрүүлсэн 15,779.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор тайлагнааж, дансны бичилт буруу хийсэн нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 5.1.4. заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. Тайлант онд 16,161.2 мянган төгрөгийн авлага, 15,837.4 мянган төгрөгийн өглөг үүсгэн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 19.1.4 заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Аудит хийх явцад тооцоо нийлсэн актаар баталгаажуулж зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

3. Жилийн эцсийн тооллогын бүртгэлтэй балансын хөрөнгийн дүнг тулган шалгах горим хэрэгжүүлэхэд үндсэн хөрөнгийг 4,300.6 мянга, бараа материалыг 99.2 мянга, нийт 4,399.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 12.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Аудит хийх явцад залруулга хийлгэсэн.

4. Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 22,663.3 төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

5. Оны эцэст үндсэн хөрөнгө худалдан авахад 4,300.6 мянга, ургал засварын зардалд 1,067.0 мянга нийт 5,367.6 мянган төгрөгийн зардал гаргасан нь УИХ-ын 2016 оны 47 тоот тогтоолын 2.в.3, 2.в.4 заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Холбогдох хууль, журам, заавар, тогтоолыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Хууль, журам, заавар мөрдөөгүйгээс шалтгаалан гарсан 5,367.6 мянган төгрөгийн алдааг залруулах боломжгүй байна.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудалгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

НАГ-2017/156/СТА-ТШ3

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 80,208.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 74,840.7 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, 5,367.6 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 7 хуудас, менежментийн захидал 4 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДЭД ДАРГА

С. ЭНХБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д. ЭНХДАЛАЙ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

И. ЭРДЭНЭЦЭГ

2017.03.09

НАГ-2017/156/СТА-ТШ3



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:
Асуудал 1
Авлага, өглөг

Асуудал 2
Зардал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:
Асуудал 1
Санхүүгийн тайлагнал

2017 оны 03 дугаар сарын 09

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Нийслэлийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидалын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Нийслэлийн аудитын газрын энэхүү зөвлөмж нь та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын ўйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Нийслэлийн Аялал жуулчлалын газрын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Авлага,өглөг

Тэргүүлэх ач холбогдол №1

НАГ-ЫН ажиглалт

Тайлант онд 16,161.2 мянган төгрөгийн авлага, 15,837.4 мянган төгрөгийн өглөг үүсгэн тооцоо нийлсэн актаар баталгаажулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохицой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалтуудыг тус тус зөрчсөн.

Эрсдэлүүд

- Санхүүгийн тайлан эрх ба үүрэг үүсэхгүй байх;

Асуудал 2: Зардал

Тэргүүлэх ач холбогдол №1

НАГ-ЫН ажиглалт

Оны эцэст үндсэн хөрөнгө худалдан авахад 4,300.6 мянга, урсгал засварын зардалд 1,067.0 мянга нийт 5,367.6 мянган төгрөгийн зардал гаргасан нь УИХ-ын 2016 оны 47 тоот тогтоолын 2.в/ "бараа үйлчилгээний зардлыг дараахь байдлаар бууруулах. Үүнд: 3/ "тавилга шинээр худалдан авахгүй байх;" 4/ "эмнэлэг, цэцэрлэг, сургуульд зайлшгүй урсгал засвар хийхээс бусад тохиолдолд төсвийн байгууллагын албан контор, ажлын байранд урсгал засвар хийхгүй байх;" заалтуудыг тус тус зөрчсөн.

Эрсдэлүүд

- Хууль, журам, заавар хэрэгжихгүй байх;

Асуудал 1: Санхүүгийн тайлагнал

НАГ-ЫН зөвлөмж

- Авлага,өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх;

Төсвийн захирагчийн хариу

- Зөвлөмж хэрэгжүүлж ажиллах хариу ирүүлсэн

Тэргүүлэх ач холбогдол №1

НАГ-ЫН зөвлөмж

- Холбогдох хууль, журам, заавар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах;

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч хариу ирүүлсэн.

Тэргүүлэх ач холбогдол №2

НАГ-ЫН ажиглалт

1. Татан төвлөрүүлсэн 15,779.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор тайлагнаж, дансны бичилт буруу хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4."үнэн зөв байх;" заалтыг зөрчсөн.

2. Жилийн эцсийн тооллогын бүртгэлтэй балансын хөрөнгийн дүнг тулган шалгах горим хэрэгжүүлэхэд үндсэн хөрөнгийг 4,300.6 мянга, бараа материалыг 99.2 мянга, нийт 4,399.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2 "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчтэй хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайллан тэнцэлд тусгаж тайлагнана;" заалтуудыг тус тус зөрчсөн.

3. Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 22,663.3 төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4."үнэн зөв байх;" заалтыг зөрчсөн.

Эрсдэлүүд

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

НАГ-ЫН зөвлөмж

- Санхүүгийн тайланд залруулга хийх;
- Зөрчлийг давтан гаргахгүй байх;
- Санхүүгийн тайланд залруулга хийх;

Төсвийн захирагчийн хариу

- Санхүүгийн тайланд залруулга хийж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаа илэрхийлсэн хариу ирүүлсэн.

ХЯНАСАН:

ДЭД ДАРГА

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

С.ЭНХБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ЭНХДАЛАЙ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Байгууллагаас ирүүлсэн хариу

С. Энхбаатарын
Ц. Оюун
III/7

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 15, Ж.Самбуугийн гудамж,
Нийислэлийн засаг захиргааны IV байр
Утас/Факс: 7012-8687
E-mail: info@tourism.ub.gov.mn
<http://www.tourism.ub.gov.mn>

2017.03.09 № 01/95
танай 2017.02.20 -ны № 257 -т

Г НИЙСЛЭЛИЙН АУДИТИН ГАЗАРТ Г

Тус газрын 2016 оны жилийн эцсийн
санхүүгийн тайланд хийсэн аудитын шалгалтын
зөрчилтэй асуудлын бүртгэлтэй танилцаа.

Цаашид танай газраас ирүүлсэн зөвлөмжийн
дагуу ажиллах болно.



1150500145

НАГ-2017/156/СТА-ТШЗ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,680,169.00	27,756,582.00
33	АВЛАГА	-	16,161,192.00
335	Бусад авлага	-	16,161,192.00
3351	Байгууллагаас авах авлага	-	16,161,192.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,680,169.00	11,595,390.00
354	Хангамжийн материал	9,680,169.00	11,595,390.00
35410	Бичиг хэргийн материал	4,050,177.00	5,963,431.00
35420	Аж ахуйн материал	1,483,444.00	1,326,295.00
35430	Сэлбэг хэрэгсэл	176,000.00	176,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,970,548.00	4,129,664.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	49,156,568.67	42,152,133.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	49,156,568.67	42,152,133.56
392	Биет хөрөнгө	41,652,568.48	36,576,633.56
39205	Машин, тоног төхөөрөмж	55,251,766.00	59,002,766.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(31,535,344.12)	(38,783,621.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,413,200.00	32,962,800.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,077,053.40)	(19,327,533.64)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,000,000.00	5,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,400,000.00)	(2,277,777.80)
393	Биет бус хөрөнгө	7,504,000.19	5,575,500.00
39301	Програм хангамж	9,384,000.00	9,384,000.00
39302	Хасагдуулга	(1,879,999.81)	(3,808,500.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	58,836,737.67	69,908,715.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	15,837,403.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	15,837,403.00
413	Өглөг	-	15,837,403.00
4136	Бусад өглөг	-	15,837,403.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	15,837,403.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	58,836,737.67	54,071,312.56
51	Засгийн газрын хувь оролцоо	58,836,737.67	54,071,312.56
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	60,000,000.00	60,000,000.00
51102	-Хувийн	60,000,000.00	60,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	(1,163,262.33)	(5,928,687.44)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,163,262.33)	(1,163,262.33)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(4,765,425.11)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	58,836,737.67	69,908,715.56

НАГ-2017/156/СТА-ТШ3

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	753,503,728.77	681,835,548.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	753,503,728.77	681,835,548.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,260,828.77	457,392,848.60
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	480,075,523.00	438,392,848.60
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	20,000,000.00	19,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	253,242,900.00	224,442,700.00
132001	Ургал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,242,900.00	224,442,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	738,910,537.30	686,600,973.71
21	ҮРСГАЛ ЗАРДАЛ	710,563,330.99	661,825,057.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	710,563,330.99	661,825,057.94
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	163,676,598.00	154,317,477.00
210101	Цалин	125,849,726.00	117,484,985.90
210102	Нэмэгдэл цалин	24,916,672.00	24,937,591.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,910,200.00	11,894,900.00
2102	Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,857,963.00	17,917,499.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,715,084.00	11,342,011.43
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,453,151.00	1,328,611.25
210203	ҮОМШ ёвчний даатгалын шимтгэл	1,778,040.00	1,639,646.32
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	355,609.00	327,928.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,556,079.00	3,279,302.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,540,400.00	282,000.00
210304	Байрны түрээс	-	282,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,591,173.46	17,862,082.83
210401	Бичиг хэргийн материал	7,659,410.00	8,675,729.00
210402	Тээвэр, шатахууны зардал	6,519,464.00	5,396,403.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	3,357,299.46	3,789,950.83
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	481,428,794.00	418,272,538.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	480,498,669.00	417,528,538.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	930,125.00	744,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,572,402.53	53,173,461.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,394,289.00	39,868,426.00

НАГ-2017/156/СТА-ТШ3

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,178,113.53	13,305,035.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,347,206.31	24,778,915.77
2132	Бусад ургал шилжүүлэг	18,082,600.00	10,325,810.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	18,082,600.00	10,325,810.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,264,606.31	14,450,105.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,264,606.31	14,450,105.77
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	14,593,191.47	(4,765,425.11)
7	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	14,593,191.47	(4,765,425.11)

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	753,503,728.77	681,835,548.60
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	753,503,728.77	681,835,548.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,260,828.77	457,392,848.60
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангиллагаагүй нөөц хөрөнгөнөөс	480,075,523.00	433,912,822.60
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдан төсвөөс олгосон санхүүжилт	20,000,000.00	19,000,000.00
131106	Төсвийн урамшуулал	185,305.77	4,480,026.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	253,242,900.00	224,442,700.00
132001	Ургал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	253,242,900.00	224,442,700.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	730,890,998.77	677,534,948.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	730,890,998.77	677,534,948.60
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	702,573,792.46	636,211,826.83
2101	Цалин, хэлс болон нэмэгдэл урамшил	162,233,822.00	154,473,406.00
210101	Үндсэн цалин	121,341,643.00	114,504,091.00
210102	Нэмэгдэл	28,124,579.00	27,551,315.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,767,600.00	12,418,000.00
2102	Ажил олгоочос нийтийн даатгалд төлөх шимтгэл	17,895,116.00	17,917,499.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	11,388,400.00	17,917,499.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	9,540,400.00	282,000.00
210304	Байрны түрээс	00.00	282,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,049,973.46	19,393,053.83
210401	Бичиг хэрэг	8,078,210.00	10,229,800.00
210402	Тээвэр, шатахуун	6,519,464.00	5,396,403.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,357,299.46	3,766,850.83

НАГ-2017/156/СТА-ТШ3

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧДАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2106	Эд хогшил, ургал засварын зардал	00.00	179,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	00.00	179,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	485,564,192.00	419,377,408.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	484,924,192.00	417,863,408.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	640,000.00	1,514,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,394,289.00	24,589,460.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,394,289.00	24,589,460.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,317,206.31	41,323,121.77
2132	Бусад ургал шилжүүлэг	18,052,600.00	11,094,050.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	18,052,600.00	11,094,050.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,264,606.31	30,229,071.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,264,606.31	30,229,071.77
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	22,612,730.00	4,300,600.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	22,612,730.00	4,300,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,612,730.00	4,300,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,612,730.00	4,300,600.00
225102	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /ТӨҮГ/	22,612,730.00	4,300,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-22,612,730.00	-4,300,600.00
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	60,000,000.00		(15,756,453.80)	44,243,546.20
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,000,000.00		(15,756,453.80)	44,243,546.20
C07	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			14,593,191.47	14,593,191.47
D01	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	60,000,000.00		(1,163,262.33)	58,836,737.67
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,000,000.00		(1,163,262.33)	58,836,737.67

НАГ-2017/156/СТА-ТШ3

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

D08	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			(4,765,425.11)	(4,765,425.11)
D09	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	60,000,000.00		(5,928,687.44)	54,071,312.56

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилаал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	258,289,300.00	215,995,468.83	42,293,831.17	83.6
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	258,289,300.00	215,995,468.83	42,293,831.17	83.6
210	Бараа, үйлчилгээний зардал	223,989,300.00	204,901,418.83	19,087,881.17	91.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,812,800.00	154,473,406.00	10,339,394.00	93.7
210101	Үндсэн цалин	121,344,700.00	114,504,091.00	6,840,609.00	94.4
210102	Нэмэгдэл	30,085,500.00	27,551,315.00	2,534,185.00	91.6
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	13,382,600.00	12,418,000.00	964,600.00	92.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,162,500.00	17,917,499.00	1,245,001.00	93.5
210201	Тэтгэврийн даатгал	12,570,000.00	17,917,499.00	-5,347,499.00	142.5
210202	Тэтгэмжийн даатгал	1,318,500.00	00.00	1,318,500.00	0.0
210203	ҮОМШӨ ний даатгал	1,648,100.00	00.00	1,648,100.00	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	329,600.00	00.00	329,600.00	0.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,296,300.00	00.00	3,296,300.00	0.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,600,000.00	282,000.00	3,318,000.00	7.8
210304	Байрны түрээс	3,600,000.00	282,000.00	3,318,000.00	7.8
2104	Хангамж, бараа материалын зардал	20,580,000.00	19,393,053.83	1,186,946.17	94.2
210401	Бичиг хэрэг	9,880,000.00	10,229,800.00	-349,800.00	103.5
210402	Тээвэр (шатахуун)	6,200,000.00	5,396,403.00	803,597.00	87.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,500,000.00	3,766,850.83	733,149.17	83.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	10,184,500.00	7,186,000.00	2,998,500.00	70.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,384,000.00	5,672,000.00	2,712,000.00	67.7
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,800,500.00	1,514,000.00	286,500.00	84.1

НАГ-2017/156/СТА-ТШ3

**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

2201	Бараа үйлчилгээний бусад зардал	5,649,500.00	5,649,460.00	40.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,649,500.00	5,649,460.00	40.00	100.0
	ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,300,000.00	11,094,050.00	23,205,950.00	32.3
2132	Бусад ургсал шилжүүлэг	34,300,000.00	11,094,050.00	23,205,950.00	32.3
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	34,300,000.00	11,094,050.00	23,205,950.00	32.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	258,289,300.00	215,995,468.83	42,293,831.17	83.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	258,289,300.00	215,995,468.83	42,293,831.17	83.6
132001	Орон нутгийн төсвөөс	258,289,300.00	215,995,468.83	42,293,831.17	83.6
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18	18	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	01	01	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	00.0	00.0	00.0	0.0

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		451,389,974.60
21	ҮРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		451,389,974.60
210	Бараа, үйлчилгээний зардал		435,611,008.00
2106	Эд хогшил худалдан авах		4,479,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		4,479,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		412,191,408.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		412,191,408.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал		18,940,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		18,940,000.00
	ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		15,778,966.60
2131	Засгийн газар хоорондын шилжүүлэг		15,778,966.60
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		15,778,966.60
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		451,389,974.60
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		451,389,974.60
131103	ЗГНХ. Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		427,909,948.60

НАГ-2017/156/СТА-ТШ3

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		19,000,000.00
131106	Төсвийн урамшуулал		4,480,026.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		00.00

НАГ-2017/156/СТА-ТШЗ